



СИ ПИ ТИ ЭЙ АУДИТ ХХК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Шинэ-Идэр Дулаан Эрдэнэт ХХК-ийн 2023 оны
жилийн эцсийн санхүүгийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2024/04/НА-СТА-ОНА

Цахим хуудас:

www.audit.mn

Хөвсгөл аймаг

2024 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн Аудитын Газрын
Дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatar@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр
Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn

Аудитор: Л.Мандахнаран
Утас: 99389927 Цахим хаяг: mandakhnaranL@audit.gov.mn

Аудитыг гүйцэтгэсэн: Си Пи Ти Эй Аудит ХХК-ийн
Захирал: Ч.Энхчимэг
Утас: 77233030 Цахим хаяг: info@cptaaudit.mn

Аудитор: Т.Мөнхзул
Утас: 77233030 Цахим хаяг: info@cptaaudit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

НЭГ. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2024.03.15 № 01/262
танай _____-ны № _____-т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН “ШИНЭ ИДЭР
ДУЛААН ЭРДЭНЭТ” ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Х.БАТТУЛГА
ТАНАА

Хараат бус аудиторын дүгнэлт

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Шинэ-Идэр Дулаан эрдэнэт” ХХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, болон тодруулгуудад аудит хийлээ.

“Шинэ-Идэр Дулаан эрдэнэт” ХХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Төлөөлөн удирдах зөвлөлөөр баталсан орлого, үр дүнгийн тайлангийн төлөвлөгөө нь оны эхэнд 481.8 сая төгрөгийн борлуулалт, 485.4 сая төгрөгийн зардалтай, 3.6 сая төгрөгийн алдагдалтай байхаар төлөвлөгдсөн ч оны дундуур 14.8 сая төгрөгийн зардал нэмэгдүүлэх тодотгол хийж, 18.4 сая төгрөгийн алдагдалтай ажиллахаар баталсан байна.

Аудитын гол асуудал

Аудитаар нийт 12.2 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой 0.4 сая төгрөгийн алдааг залруулж, цахим и-баримтгүй 11.8 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлж ажилласан.

Бусад асуудлын хэсэг

“Шинэ-Идэр Дулаан эрдэнэт ХХК нь Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 01 сарын 20-ны өдрийн 01 дугаар тогтоолоор 2023 оны бизнес төлөвлөгөөг баталж, 2023 оны 12 дугаар сарын 11-ны өдрийн 09 дугаар тогтоолоор нийт орлогыг 481.8 сая төгрөгөөр, нийт зардлыг 490.1 сая төгрөг байхаар нэмэлт тодотгол хийснээс 100.0 хувийн орлогын гүйцэтгэлтэй байна.

5724040945

Хөвсгөл аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын баталсан Эдийн засгийн зорилтот түвшний төлөвлөгөөнд суурилж, Төлөөлөн удирдах зөвлөл бизнес төлөвлөгөөгөө шинэчлэн боловсруулж, баталдаг байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  А.ЭРДЭНЭБААТАР



ХОЁР.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

	Үзүүлэлт	2023.01.01	2023.12.31
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	5,409,025.61	4,390,295.52
1.1.4	Бусад авлага	15,601,026.45	16,870,430.75
1.1.6	Бараа материал	19,403,755.32	19,174,019.32
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	40,413,807.38	40,434,745.59
1.2.1	Үндсэн хөрөнгө	646,754,339.53	630,967,017.96
1.2.2	Биет бус хөрөнгө	14,258,041.67	14,132,000.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	661,012,381.20	645,099,017.96
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	701,426,188.58	685,533,763.54
2.1.1.1	Дансны өглөг	193,978.79	358,523.93
2.1.1.2	Цалингийн өглөг	(0.00)	4,570.99
2.1.1.3	Татварын өр	4,558,002.07	6,526,588.05
2.1.1.9	Хойшлогдсон албан татварын өр	928,020.32	486,983.45
2.1.1.12	ХАОАТ өглөг	(0.00)	(0.00)
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	5,680,001.18	7,376,666.41
2.2	Өр төлбөрийн нийт дүн	5,680,001.18	7,376,666.41
2.3.1	Өмч: - төрийн	687,676,437.96	687,676,437.96
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	207,155,817.14	207,155,817.14
2.3.8	Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	24,539,500.00	24,539,500.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(223,625,567.69)	(241,214,657.97)
2.3.11	Эзэмшигчдийн өмчийн дүн	695,746,187.41	678,157,097.13
2.4	Өр төлбөр ба эзэмшигчдын өмчийн дүн	701,426,188.58	685,533,763.54

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Борлуулалтын орлого(цэвэр)	474,004,641.26	482,300,092.64
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	396,486,239.91	415,634,422.80
3	Нийт ашиг (алдагдал)	77,518,401.36	66,665,669.83
4	Хүүний орлого	0.00	29,585.91
5	Ерөнхий ба удирдлагын зардал	76,067,621.50	84,643,324.28
6	Санхүүгийн зардал	83,400.00	79,100.00
7	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	1,367,379.86	(18,027,168.54)
8	Орлогын татварын зардал	928,020.30	438,078.28
9	Татварын дараах ашиг (алдагдал)	439,359.56	(17,589,090.26)
10	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	439,359.56	(17,589,090.26)
11	Орлогын нийт дүн	439,359.56	(17,589,090.26)

Шинэ-Идэр Дулаан Эрдэнэт ХХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	НИЙТ ДҮН
2022 оны 1-р сарын 1- ний үлдэгдэл	687,676,437.96	205,380,817.14	14,132,000.00	(224,064,927.25)	683,124,327.85
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	439,359.54	439,359.54
Өмчид гарсан өөрчлөлт	0.00	1,775,000.00	10,407,500.00	0.00	12,182,500.00
2023 оны 01-р сарын 01-ний үлдэгдэл	687,676,437.96	207,155,817.14	24,539,500.00	(223,625,567.69)	695,746,187.41
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	(17,589,090.26)	(17,589,090.26)
2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	687,676,437.96	207,155,817.14	24,539,500.00	(241,214,657.97)	678,157,097.13

Шинэ-Идэр Дулаан Эрдэнэт ХХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	526,020,070.21	529,628,933.60
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	526,020,070.21	529,237,888.60
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	0.00	391,045.00
1.2	Мөнгөн зарлага (-)	473,063,477.45	500,263,291.01
	Ажиллагчдад төлсөн	161,453,795.38	180,816,821.00
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	43,798,703.61	52,846,046.43
	Бараа материал худалдан авахад төлсөн	84,282,899.00	77,346,875.00
	Ашиглалтын зардалд төлсөн	73,305,590.33	100,707,187.62
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	64,720,075.00	47,104,635.20
	Татварын байгууллагад төлсөн	38,704,528.63	39,078,480.76
	Даатгалын төлбөрт төлсөн	82,875.00	0.00
	Бусад мөнгөн зарлага	6,715,010.50	2,363,245.00
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	52,956,592.76	29,365,642.59
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	0.00	1,701,585.91
	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	0.00	1,672,000.00
	Хүлээн авсан хүүний орлого	0.00	29,585.91
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	66,822,000.00	32,083,000.00
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	66,822,000.00	32,083,000.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(66,822,000.00)	(30,381,414.09)
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	7,000,000.00	0.00
	Төлсөн ногдол ашиг	7,000,000.00	0.00
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(7,000,000.00)	0.00
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(20,865,407.24)	(1,015,771.50)
5	МӨНГӨ ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	26,274,432.85	5,409,025.61
	МӨНГӨ ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	5,409,025.61	4,390,295.52

Шинэ-Идэр Дулаан Эрдэнэт ХХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

2.5 ТУЗ-аар батлагдсан бизнес төлөвлөгөө, гүйцэтгэл

/төгрөгөөр/

	Зардлын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт хувиар
1	Халаалтын орлого	479,251,083.00	478,464,150.64	(786,932)	100%
2	Цэвэр усны орлого	1,563,635.00	2,799,579.00	1,235,944	179%
3	Түрээсийн орлого	1,036,363.00	1,036,363.00	-	100%
4	Бусад орлого	-	29,585.91	29,586	0%
	Орлогын дүн	481,851,081.00	482,329,678.55	478,598	100%
1	Цалин хөлс, нэмэгдэл, урамшуулал	196,376,256.00	194,510,101.00	(1,866,155)	99%
2	НДШимтгэлийн зардал	28,461,795.00	28,460,782.00	(1,013)	100%
3	Нүүрс	55,590,910.00	55,578,641.00	(12,269)	100%
4	Шатахуун	6,363,636.00	11,952,266.00	5,588,630	188%
5	Тээврийн зардал	66,954,545.00	66,954,000.00	(545)	100%
6	Гэрэл цахилгаан	53,636,363.00	53,574,793.00	(61,570)	100%
7	Бичиг хэрэг	1,200,000.00	1,056,390.60	(143,609)	88%
8	Цахилгаан холбоо	1,000,000.00	1,000,000.00	-	100%
9	Албан томилолт	800,000.00	788,000.00	(12,000)	99%
10	Газар ус ашигласан төлбөр	500,000.00	500,000.00	-	100%
11	Хөдөлмөр хамгаалал	11,574,000.00	11,047,454.55	(526,545)	95%
12	Урсгал засвар	7,500,000.00	11,372,363.94	3,872,364	152%
13	Төлбөр хураамж, аудит зардал	2,000,000.00	2,000,000.00	-	100%
14	ТУЗ зардал	6,475,011.00	6,357,168.00	(117,843)	98%
15	ТХ Татвар даатгал	300,000.00	269,500.00	(30,500)	90%
16	ҮХХ-ийн татварын зардал	300,000.00	200,000.00	(100,000)	67%
17	Тэтгэмж урамшуулал нийгмийн асуудал	6,500,000.00	6,462,288.00	(37,712)	99%
18	ЭХЗЗ-ийн үйлчилгээний хөлс	1,500,000.00	1,341,545.00	(158,455)	89%
19	Элэгдэлийн зардал	39,000,000.00	46,852,454.00	7,852,454	120%
20	Ноогдол ашиг	-			
21	Банкны шимтгэл	80,000.00	79,100.00		
22	Нийт үйл ажиллагааны зардлын дүн	500,277,747.09	500,356,847.09	(79,100)	100%
23	Татварын өмнөх ашиг /алдагдал/	(18,426,666.09)	(18,027,168.54)	(399,498)	98%
24	ААНОАТ-ын зардал		438,078.28		
25	Татварын дараах ашиг /алдагдал/	(18,426,666.09)	(17,589,090.26)		

ГУРАВ. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 12.2 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 0.4 сая төгрөгийн алдааг залруулж, 11.8 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгч, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх нийт 2 зөвлөмж өглөө.

Аудитаар залруулагдаагүй зөрчилтэй асуудлын материаллаг бус алдаа зөрчил нь 11.8 сая төгрөг байгаа тул **Өөрчлөлтгүй** дүгнэлт өглөө.

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- ААНОАТ болон санхүүгийн тайлан дахь хойшлогдсон татварын өглөг, хөрөнгийг зөрүүтэй тайлагнасан 0.4 сая төгрөгийг залруулсан.

5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Цалингийн зардалтай холбоотой

Илрүүлэлт: Бодогдсон цалингаас, НДШ-ийн тайланг 2.7 сая төгрөгөөр код зөрүүлэн тайлагнасан /үндсэн ажилтнаар тайлагнах ажилтан сул зогсолтоор тайлагнасан/ нь НББ-ийн тухай хуулийн 5.1.4 “Үнэн зөв байх” Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1 “Хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх” 17.1.3 “Нийгмийн даатгалын холбогдолтой анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийг тогтоосон журмын дагуу хөтөлж, тайлан тэнцэл гаргах” гэсэн заалтуудтай нийцээгүй бөгөөд “Үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Цалингийн тооцооллыг үнэн зөв тооцоолж, ажил хариуцсан ажилтны ажлын хариуцлагыг сайжруулж ажиллах

2. Худалдан авалттай холбоотой

Илрүүлэлт: Худалдан авалттай холбоотой 11.8 сая төгрөгийн гүйлгээ нь анхан шатны баримттай боловч цахим и-баримтгүй байгаа нь орлогын албан татварын тухай хуулийн 13-р зүйлийн 13.1.4; “Доор дурдсан бараа, ажил, үйлчилгээний зардал Татварын ерөнхий хуулийн 28.5-д заасан дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримт, импортын бараанд татвар ногдуулж, гаалийн байгууллагад төлсөн тухай баримтаар баталгаажсан байх” НББ-ийн тухай хуулийн 14-р зүйлийн 14.3.1. “Анхан шатны баримт бүрдүүлэх” гэж заасныг тус тус зөрчсөн ба нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Татварын ерөнхий хуулийн 28.5-д заасан дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг баталгаажуулж байх

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5. Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ гэж заасны дагуу аудитаар илэрсэн зөрчлийг арилгаж ажиллах ажлын төлөвлөгөөг боловсруулан 2024 оны 04 дугаар сарын 25-ний өдрийн дотор, зөвлөмж, албан шаардлагын биелэлтийг 2024 оны 9 дүгээр сарын 30-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

ДӨРӨВ. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
							Залруулсан		Залруулаагүй	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ААНОАТ болон санхүүгийн тайлан дахь хойшлогдсон татварын өглөг, хөрөнгийг зөвөөр тооцож, зөрүүгийн тайланд оруулаагүй	1	0.4			1	0.4	1	0.4		
Дүн	1	0.4			1	0.4	1	0.4		

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бодогдсон цалингаас, НДШ-ийн тайланг 2.7 сая төгрөгөөр код зөрүүлэн тайлагнасан /01 кодоор тайлагнах ажилтанг 25 кодоор тайлагнасан/	1						1	
Худалдан авалттай холбоотой цахим и-баримтгүй гүйлгээ хийсэн	1	11.8					1	11.8
дүн	2	11.8					2	11.8

ТАВ. ТӨСВИЙН ЗАХИРАГЧИЙН АНГИЛЛААР АУДИТАД ХАМРАГДСАН БАЙДАЛ БА САНАЛ ДҮГНЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙН НЭГТГЭЛ

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1				1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1				1			